



ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/27

Мөрөн сум

“Зөөлөн баг”-ийн төвийн хашаа хүлээн
авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Сумын Засаг даргын 2026 оны 03 сарын 13-ны өдрийн А/51 тоот захирамжаар байгуулагдсан Сумын ажлын хэсгийн 2026 оны 03 сарын 27-ны өдрийн 04 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1.Иргэн (Ж.Санжаадорж) нь сумын ОНХ сангийн хөрөнгө оруулалтаар “ЗӨӨЛӨН” багийн төвийн хашаа хийх ажлын сонгон шалгаруулалтад тэнцэж 2026 оны 03 сарын 27-ноос 2026 оны 05 сарын 01-ний дотор хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан тул уг ажлын явцад захиалагчийн зүгээс хөндлөнгийн хяналт байнга тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, техникийн тодорхойлолтод заасны дагуу хүлээн авах эрх бүхий сумын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: С.Сүхчулуун - “Зөөлөн” багийн Засаг дарга

Гишүүдэд: Г.Дашмаа – Төрийн сангийн мэргэжилтэн, /БӨХБЗ нарийн бичиг/


А.Энхтөр - Аж ахуйн нярав

2.Иргэн (Ж.Санжаадорж)-оос хүлээн авах “ЗӨӨЛӨН” багийн төвийн хашааг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтыг үндэслэн өнгө үзэмж, тоо ширхэг, чанар байдлыг нэг бүрчлэн шалгаж, фото зургаар баримтжуулан акт үйлдэн хүлээн авах, цаашдын ашиглалтад байнгын хяналт тавьж, засвар үйлчилгээг тогтмол хийж ажиллахыг комиссын дарга (С.Сүхчулуун)-д үүрэг болгосугай.

3.Багийн төвийн хуучин хашааг Засаг даргын Тамгын газрын аж ахуйн нярав (А.Энхтөр)-д акт үйлдэн, тоолж хүлээлгэж өгөхийг Багийн засаг дарга (С.Сүхчулуун)-д даалгасугай.

4.Шинэ хашааг хөрөнгөнд бүртгэх, хуучин хашааг цаашид яаж ашиглах талаар санал боловсруулж танилцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Т.Баяртуяа), Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Ц.Болорцэцэг) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Н.НАМЖИЛНОРОВ